

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/63/СТА-ТӨҮГ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НХА	Нэг худалдан авагч
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗЭ	Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид
ҮТЗЭ	Үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	9
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Орлого, зардлын данстай холбоотой асуудал	11
	3.1.1 Илрүүлэлт	11
	3.1.2 Эрсдэл	11
	3.1.3 Өгсөн зөвлөмж	11
	3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар	11
3.2	Зардлын данстай холбоотой асуудал	11
	3.2.1 Илрүүлэлт	11
	3.2.2 Эрсдэл	12
	3.2.3 Өгсөн зөвлөмж	12
	3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар	12
3.3	Зардалтай холбоотой асуудал	12
	3.3.1 Илрүүлэлт	12
	3.3.2 Эрсдэл	12
	3.3.3 Өгсөн зөвлөмж	12
	3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	15
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	17
5	Хавсралт	19
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАЛЖИННЯМ ТАНАА

2019.03.20 № 06/520
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Диспетчерийн үндэсний төв” ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 04-нөөс 2019 оны 03 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Баян суварга Аудит” ХХК-ийн аудитор Н.Бат-Оюун хариуцаж хэрэгжүүлэв.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 01/254 дүгээр бүхий албан бичгээр “Лайэн Аудит” ХХК-д хүргүүлснийг “Баян суварга Аудит” ХХК-д шилжүүлж хүргүүлсэн болно.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Диспетчерийн үндэсний төв” ХХК нь “Оновчтой зохицуулалт, чанартай эрчим хүчийг үндэсний хэмжээнд” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааг хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн диспетчерийн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах
- Цахилгаан дамжуулах гол шугам, холбогдох барилга байгууламжийн технологи, техник эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв
- Цахилгаан эрчим хүчний экспорт, импортын зохицуулалт хийх
- Нэгдсэн сүлжээний горим тооцоо, реле хамгаалалт, автоматик, шуурхай удирдлага, холбоо мэдээллийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх
- Нэгдсэн сүлжээний арилжааны үйл ажиллагааг удирдан явуулах ажлыг зохион байгуулж, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх загварыг боловсронгуй болгох.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн удирдлага сангийн сайдын баталсан нягтлан бодох, бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль
- Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм /Эрчим хүчний сайдын 2014 оны 05 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт/

- Уурын ба ус халаалалтын зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм /Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010 оны 127 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт/
- Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм /Эрчим хүчний сайдын 2014 оны 101 дугаар тушаал/
- Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын аюулгүй, найдвартай ажиллагааг хангахад шаардлагатай түлш болон тоног төхөөрөмж, сэлбэг, материалын аюулгүйн нөөцийг бүрдүүлэх журам /Түлш, эрчим хүчний сайдын 2007 оны 53 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт/.

Тайлант хугацаанд “Диспетчерийн үндэсний төв” ХХК “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинээр боловсруулж, тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар тогтоолоор батлуулан мөрдөж байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ санхүүгийн тооцоолохын Ординат ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн “unicus” програм, мөн “Нэг худалдан авагчтай загвар”-ын тайлан бүртгэлд “sbm.energy.mn” програм хангамжийг тус тус ашигладаг байна.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлтээр сонгож, түүний 1 хувиар материаллаг байдлын түвшинг тооцов.

Аж ахуйн нэгжийн хувьд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгосон нь байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, үр дүн нь нийт зардлаас хамааралтай. Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт зардлын дүнгээс гүйцэтгэлийн шатанд дахин тогтоов.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаарх нийт зардал 727,221.5 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 7,272.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорил түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- 2018 онд худалдан авсан 110.8 сая төгрөгийн өртөг бүхий “тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данс хуваарилалтын програм хангамж”-ийг 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй барилга нэрээр тайлагнасныг биет бус хөрөнгө дансанд шилжүүлэн залруулах бичилт хийлгэсэн.
- Түүнчлэн мөнгөн гүйлгээний тайланд биет болон биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн зардлыг 60.2 сая төгрөгөөр ангилал хооронд зөрүүтэй тайлагнасныг залруулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	48.3	
2	Албан шаардлага	1	59.6	
	Дүн		107.9	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1:

Компанийн диспетчерийн зохицуулалтын санхүүгийн тайлангаар 2018 оны эцэст 1,072.5 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан. Үүнээс 3 байгууллага, хувь хүнтэй холбоотой 59.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заалттай нийцэхгүй байна.

Шийдэл:

Нэр бүхий 3 байгууллага, хувь хүнтэй холбоотой 59.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулан барагдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар Албан шаардлага хүргүүлсэн.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно. Дараагийн аудитаар “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгийн дахин үнэлгээг нягтлан шалгаж дүгнэх нь зүйтэй гэж үзлээ.

2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, тайлагнах, мөн хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу эрх, үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар компанийн гүйцэтгэх захирал нь зорилтот түвшин, төлөвлөгөөний биелэлтийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой нийт 36 заалт бүхий 4 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, зардлын болон бизнес төлөвлөгөөг ТУЗ-ийн 2018 оны 06, 37 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

Зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 2018 онд 5,444.9 сая төгрөгийн орлого олж, 5,430.3 сая төгрөгийн зардал гарган 14.6 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажиллахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 6,268.5 сая төгрөгийн орлого олж, 6,093.6 сая төгрөгийн зардал гаргаж, 174.8 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажиллаж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардалд 5.9 сая төгрөг төлөхөөр гарч 168.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тус компани “Нэг худалдан авагч (НХА)-тай загвар”-ын хүрээнд нийт 15 үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид /ҮТЗЭ/-ээс цахилгаан эрчим хүч худалдан авч, нийт 22 Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид /ТТЗЭ/-эд цахилгаан эрчим хүч худалдан борлуулж төлбөр тооцоог хийж байна. Тайлант онд “Нэг худалдан авагчтай загвар”-ын тайлангаар нийт 715,040.3 сая төгрөгийн орлого олж, 721,128.1 сая төгрөгийн зардал гаргаж, 6,088.5 сая төгрөгийн алдагдалтай тайлагнагдсан.

“Нэг худалдан авагчтай загвар”-ын нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 2018 онд нийт 721,301.9 сая төгрөгийн орлого, 727,221.5 сая төгрөгийн зардал, 5,919.6 сая төгрөгийн алдагдалтайгаар тайлагнагдсан бөгөөд авлага өмнөх оноос 7,835.6 сая төгрөгөөр, өглөг 13,626.8 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

“Диспетчерийн үндэсний төв” ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК нь 2018 онд нийт 2 ангиллаар 7 төрлийн 155 мэдээллийг хуулийн хугацаанд цахим хуудсанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгсөнийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэдүндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлого, зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөөгөөр төлбөрт үйлчилгээний орлогыг ТӨБЗГ-ын 2017 оны 658 дугаар, ТУЗ-ийн 06 дугаар тогтоолуудын дагуу 14.5 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 326.1 сая төгрөгийн орлоготой ажилласнаас үзэхэд төлөвлөлт үндэслэлтэй хийгдээгүй байна.

2018 онд зорилтот түвшний зардал батлагдсан төлөвлөгөөнөөс нийт дүнгээр хэтрээгүй боловч систем хангамжийн зардал 10.7 сая төгрөг, гадаад томилолтын зардал 2.0 сая төгрөг, автомашины урсгал засварын зардал 2.7 сая төгрөг, баяр ёслолын арга хэмжээний зардал 5.0 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн, мөн үндсэн бус үйл ажиллагааны төлөвлөгдөөгүй 16.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.

3.1.2 Эрсдэл:

Орлого, зардлын төлөвлөлт, тайлан тооцоонд тавих хяналт суларч, холбогдох эрхийн акт зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Орлого, зардлын төлөвлөгөөг тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан зардлын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, үр ашиггүй зардал гаргахгүй ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тус компанийн ТУЗ-ийн 2018 оны 17 дугаар тогтоолоор ТӨБЗГ-ын мэргэжилтний гадаад томилолтын зардалд 8.3 сая төгрөг, Шинжлэх ухааны их сургуулийн “Эрчим” багт олон улсын тэмцээнд оролцох зардалд 3.0 сая төгрөгийг тус тус олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Үр ашиггүй зардал гаргах, зардлын тооцоонд тавих хяналт суларч, холбогдох эрхийн акт зөрчигдөх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж гадны байгууллага, иргэдэд хандив, тусламж олгож үр ашиггүй зардал гаргадаг асуудлыг таслан зогсоох.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

3.3 Зардалтай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Компанийн 2018 оны зорилтот түвшин, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай ТӨБЗГ-ын 2017 оны 658 дугаар тогтоол, ТУЗ-ийн 2018 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу шуурхай ажиллагааны зориулалтаар туулах чадвар сайтай Ланд-TLC200 маркын автомашиныг 228.0 сая төгрөгөөр “Таван богд” компаниас 2018 оны 9 дүгээр сард худалдан авсан байна.

Гэвч уг автомашиныг тус компанийн гүйцэтгэх захирал хот дотор зориулалт бусаар ашиглаж, шатахууны үргүй зардал гаргаж байна.

Энэ нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 1-д ... “албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтныг хавсралтаар баталсугай”, 2-д “албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500 см³-ээс илүүгүй байхаар тогтоож, ажлын хоногт дунджаар 40 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай” заалтыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Төрийн өмчийн ашиглалт, автомашины шатахууны зарцуулалтад тавих хяналт суларч, холбогдох эрхийн акт зөрчигдөх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид албан ажлын болон тусгай зориулалтын автомашины ашиглалтад тавих хяналтыг сайжруулж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн 2018 оны Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Балансын үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,904,247,851.23	3,718,645,922.72
Дансны авлага	30,833,712,859.14	38,100,826,238.32
Татвар, НДШ-ийн авлага	678,553,530.53	1,226,199,982.22
Бусад авлага	2,568,557.82	23,331,196.77
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	264,112,404.39	258,274,760.82
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	42,886,092.00	-
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	35,726,081,295.11	43,327,278,100.85
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	9,065,643,789.96	8,749,648,858.68
Биет бус хөрөнгө	4,101,386,858.28	3,566,329,666.07
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
Дуусаагүй барилга	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,167,030,648.24	12,315,978,524.75
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	48,893,111,943.35	55,643,256,625.60
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	18,882,128,576.57	35,946,655,284.45
Цалингийн өглөг	-	-
Татварын өр	877,675,578.23	95,820,171.67
НДШ-ийн өглөг	1,788,005.52	-
Ногдол ашгийн өглөг	-	347,200.00
Урьдчилж орсон орлого	-	-
Нөөц /өр төлбөр/	3,208,929,421.93	-
Бусад богино хугацаат өр төлбөр	4,591,914,605.10	5,045,747,715.58
Богино хугацаат өр төлбөрийн дүн	27,562,436,187.35	41,088,570,371.70
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	9,197,761,635.45	8,718,544,788.43
Нөөц /өр төлбөр/	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	1,856,843,108.13	2,478,968,009.32
Урт хугацаат өр төлбөрийн дүн	11,054,604,743.58	11,197,512,797.75
Өр төлбөрийн нийт дүн	38,617,040,930.93	52,286,083,169.45
Эздийн өмч		
Өмч: - төрийн	1,842,324,959.90	1,811,705,231.02
- хувийн	-	-
- хувьцаат	-	-

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	110,468,306.50
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	1,125,780,613.55	3,406,082.55
Хуримтлагдсан ашиг	7,307,965,438.97	1,431,593,836.08
Тайлангийн үеийн ашиг	-	(5,919,567,862.14)
Өмнөх үеийн ашиг	7,307,965,438.97	7,351,161,698.22
Эздийн өмчийн дүн	10,276,071,012.42	3,357,173,456.15
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	48,893,111,943.35	55,643,256,625.60

4.2 Аудит хийсэн 2018 оны Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого (цэвэр)	619,526,834,867.58	718,815,636,476.92
Борлуулалтын өртөг	615,583,926,209.49	724,383,155,045.29
Нийт ашиг (алдагдал)	3,942,908,658.09	(5,567,518,568.37)
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	125,771,517.27	188,137,663.14
Ногдол ашгийн орлого	-	-
Бусад орлого	1,075,959,432.98	2,298,122,210.52
Орлогын дүн	1,201,730,950.25	2,486,259,873.66
Борлуулалт, маркетингийн зардал	356,006,032.77	418,026,036.43
Ерөнхий ба удирдлагын зардал	705,475,743.22	945,468,411.11
Санхүүгийн зардал	123,509,506.78	197,524,416.60
Бусад зардал	3,237,567,421.93	32,539,800.00
Зардлын дүн	4,422,558,704.70	1,593,558,664.14
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(64,243,825.30)	(762,961,004.87)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	6,545,454.55
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	(334,158,261.96)	(469,521,186.66)
Олз, гарзын дүн	(398,402,087.26)	(1,225,936,736.98)
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	323,678,816.38	(5,900,754,095.83)
Орлогын татварын зардал	288,963,770.13	18,813,766.31
Хойшлогдсон татварын зардал	-	-
Татварын дараах ашиг (алдагдал)	34,715,046.25	(5,919,567,862.14)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	34,715,046.25	(5,919,567,862.14)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	-	-
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

4.3 Аудит хийсэн 2018 оны Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оын 12 сарын 31-нээрх үлдэгдэл	1,842,324,959.90	-	3,406,082.55	6,673,905,994.84	8,516,230,954.74
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	1,122,374,531.00	599,344,397.88	1,721,718,928.88
Залруулсан үлдэгдэл	1,842,324,959.90	-	1,125,780,613.55	7,273,250,392.72	10,237,949,883.62
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	34,715,046.25	34,715,046.25
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2017 оын 12 сарын 31-нээрх үлдэгдэл	1,842,324,959.90	-	1,125,780,613.55	7,307,965,438.97	10,276,071,012.42
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(30,619,728.88)	30,619,728.88	(1,122,374,531.00)	43,196,259.25	(1,079,178,271.75)
Залруулсан үлдэгдэл	1,811,705,231.02	30,619,728.88	3,406,082.55	7,351,161,698.22	9,196,892,740.67
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(5,919,567,862.14)	(5,919,567,862.14)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	79,848,577.62	-	-	-
2018 оын 12 сарын 31-нээрх үлдэгдэл	1,811,705,231.02	110,468,306.50	3,406,082.55	1,431,593,836.08	3,357,173,456.15

4.4 Аудит хийсэн 2018 оны Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвао болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	578,547,756,469.07	674,641,936,988.41
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	577,866,409,333.13	673,774,286,758.37
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,868,577.00	7,791,000.00
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	670,478,558.94	859,859,230.04
Мөнгөн зарлагын дүн (-)	576,428,593,338.97	673,798,899,550.17
Ажиллагчдад төлсөн	2,135,170,797.95	2,439,977,405.62
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	473,625,383.81	593,275,474.81
Бараа материал худалдан авахад төлсөн	563,697,386,766.19	659,788,286,325.75
Ашиглалтын зардалд төлсөн	48,603,651.38	166,048,580.05
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	49,490,545.00	64,254,445.00
Хүүний төлбөрт төлсөн	123,509,506.78	197,524,416.48
Татварын байгууллагад төлсөн	8,892,381,710.80	10,289,884,162.69
Даатгалын төлбөрт төлсөн	3,719,958.00	19,952,078.22
Бусад мөнгөн зарлага	1,004,705,019.06	239,696,661.55
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,119,163,130.10	843,037,438.24
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	125,771,517.21	195,337,663.14
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	7,200,000.00
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хүлээн авсан хүүний орлого	125,771,517.21	188,137,663.14
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Бусад	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	1,215,086,060.15	747,270,802.05
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,019,190,762.45	585,305,682.05
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	195,895,297.70	161,965,120.00
Бусад	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,089,314,542.94)	(551,933,138.91)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	8,933,230.48	38,688,285.46
Төрөл бүрийн хандив	-	-
Бусад	8,933,230.48	38,688,285.46
Мөнгөн зарлагын дүн (-)	361,515,876.28	515,394,513.30
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	301,520,073.32	479,216,847.14
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	3,124,350.00
Бусад	59,995,802.96	33,053,316.16
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(352,582,645.80)	(476,706,227.84)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	677,265,941.36	(185,601,928.51)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,226,981,909.87	3,904,247,851.23
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,904,247,851.23	3,718,645,922.72

5. ХАВСРАЛТ

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019.03.15			САГ-2019/63/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Диспетчерийн үндэсний төв” ХХК		Сая төгрөгөөр

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
						Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	9	10
1	Авлага, өр төлбөрийн данстай холбоотой асуудал	1	Компанийн диспетчерийн зохицуулалтын тайлангаар 2018 оны эцэст нийт 1,072.5 сая төгрөгийн авлагатай тайлагнаснаас дансны болон бусад авлага өмнөх оноос 771.5 сая төгрөгөөр өссөн. Үүнээс 3 байгууллага, хувь хүнтэй холбоотой 59.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна	59.6	Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Балжинням, Б.Баярцэнгэл
2	Орлого, зардлын данстай холбоотой асуудал	1	Тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөөгөөр төлбөрт үйлчилгээний орлогыг 14.5 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 326.1 сая төгрөгийн орлоготой ажилласнаас үзэхэд төлөвлөлт үндэслэлтэй хийгдээгүй байна. 2018 онд зорилтот түвшний зардал батлагдсан төлөвлөгөөнөөс нийт дүнгээр хэтрээгүй боловч систем хангамжийн зардал 10.7 сая төгрөг, гадаад томилолтын зардал 2.0 сая төгрөг, автомашины урсгал засварын зардал 2.7 сая төгрөг, баяр ёслолын арга хэмжээний зардал 5.0 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн, мөн үндсэн бус үйл ажиллагааны төлөвлөгдөөгүй 16.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.	37.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Балжинням, Б.Баярцэнгэл
3	Зардлын данстай холбоотой асуудал	1	Тус компанийн ТУЗ-ийн 2018 оны 17 дугаар тогтоолоор ТӨБЗГ-ын мэргэжилтний гадаад томилолтын зардалд 8.3 сая төгрөг, Шинжлэх ухааны их сургуулийн “Эрчим” багт олон улсын тэмцээнд оролцох зардалд 3.0 сая төгрөгийг тус тус олгосон байна	11.3	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Балжинням, Б.Баярцэнгэл
4	Зардлын данстай холбоотой асуудал	1	Компанийн 2018 оны зорилтот түвшин, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай ТӨБЗГ-ын 2017 оны 658 дугаар тогтоол, ТУЗ-ийн 2018 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу шуурхай ажиллагааны зориулалтаар туулах чадвар сайтай Ланд-TLC200 маркын автомашиныг 228.0 сая төгрөгөөр Таван богд компаниас 2018 оны 9 дүгээр сард худалдан авсан байна. Гэвч уг автомашиныг тус компанийн гүйцэтгэх захирал хот дотор зориулалт бусаар ашиглаж, шатахууны үргүй зардал гаргаж байна.		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Балжинням, Б.Баярцэнгэл
	Дүн			107.9			

